



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2024 оны 01 сарын 16 өдөр

Дугаар А/16

Арвайхээр сум


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолоор батлагдсан хөтөлбөрийн 1.3.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлагууд болон сумдын төрийн болон төрийн бус байгууллага, спортын холбоод, аж ахуйн нэгж, байгууллага хамт олны дунд зохион байгуулагдах “Мөнгөн өвөл” спортын өдөрлөгийн арга хэмжээний зардалд 4,580,000 (дөрвөн сая таван зуун наян мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.Дээрх 4,580,000 (дөрвөн сая таван зуун наян мянга) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Ц.Идэрсайхан)-т зөвшөөрсүгэй.

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ



И. ДОРЖСҮРЭН

6224 11 0033

Аймгийн Засаг даргын 2024 оны 16 дүгээр
сарын 16-ны өдрийн 416 дугаар
захирамжийн хавсралт



“МӨНГӨН ӨВӨЛ” СПОРТ ӨДӨРЛӨГИЙН
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨСӨВ

Д/д	Нэр төрөл	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ
1	Өргөмжлөл (шилэн)	3*85,000	255,000
2	Төрөл тус бүрийн өргөмжлөл (цаасан)	11*5000	55,000
3	Аннос	6*25,000	150,000
4	Сайхан хос шалгаруулах тэмцээний зардал	1 дүгээр байр 1*100,000 2 дугаар байр 1*80,000 3 дугаар байр 1*60,000	240,000
5	Тэшүүр (цом)	1 дүгээр байр 4*200,000 2 дугаар байр 4*150,000	1,800,000
6	Мөсний шагай (цом)	3 дугаар байр 4*100,000	
7	Мөсөн сурын харваа	1 дүгээр байр 1*150,000 2 дугаар байр 1*100,000 3 дугаар байр 1*80,000	330,000
8	Олс таталт	1 дүгээр байр 1*300,000 2 дугаар байр 1*250,000 3 дугаар байр 1*200,000	750,000
9	Нээлтийн арга хэмжээний зардал		700,000
10	Унааны зардал		300,000
11	НИЙТ ДҮН		4,580,000